



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗАР**

17120 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа,
Утас/Факс: (976) 7013 3458,
И-мэйл: foreignrelations@immigration.gov.mn,
Вэбсайт: www.immigration.gov.mn

2021.01.13 № 01/46

танай 2020.12.17 -ны № 03/2173 -Т

**МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН
АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН
С.ЦЭДЭНДАМБА ТАНАА**

Төрийн албаны тухай хуулийн 74.1 дэх хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүрэг, тайлан ирүүлэх зөвлөмжийн дагуу Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайланг нэгтгэн хавсралтаар хүргүүлэв.

Тайлангийн хавсралтад холбогдох судалгаа, мэдээллийг гаргасан болно.

Хавсралт 4 хуудастай.

ДАРГА

Н.УУГАНБАЯР

000000107

Гадаадын иргэн, харьяатын газрын
2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн
01/46 дугаар албан бичгийн хавсралт

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ**

2021 оны 01 дүгээр сарын 11

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий хэсэг

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гадаадын иргэн, харьяатын газар нь Засгийн газрын 1994 оны 107 дугаар тогтоолоор Хууль зүйн сайдын дэргэд гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх зөвлөл нэртэйгээр анх байгуулагдсан.

“Төрийн захиргааны удирдлагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын 2008 оны 43, “Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байгуулах тухай” Засгийн газрын 2008 оны 64 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар болон өргөжиж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх ажлын хүрээнд ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийг 9 гишүүнтэй байгуулсан бөгөөд агентлагийн удирдлага болон зарим албан тушаалтнууд өөр ажилд шилжсэнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 84, 374 дүгээр тогтоолоор салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг шинээр томилсон. Одоогоор салбар зөвлөл нь 6 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд томилуулах шаардлагатай агентлагийн дэд дарга Д.Мөнхбаатар, Виз, зөвшөөрөл, харьяатын газрын дарга Д.Алтанзул, Хяналт шалгалтын газрын дарга Х.Бэхбат нарын хувьд “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын дагуу удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтад тэнцсэний дараа Төрийн албаны зөвлөлд уламжлан шийдвэрлүүлэхээр хүлээгдэж байна.

Байгууллагын бүтцэд батлагдсан 306 орон тооны 216 буюу 70.5 хувь нь төрийн захиргааны, 90 буюу 29.4 хувийг төрийн үйлчилгээний ажлын байр эзэлж байна. Төрийн захиргааны нийт 216 албан тушаалыг албан тушаалын ангилалаар авч үзвэл: тэргүүн түшмэл 1 буюу 0.4 хувь, эрхэлсэн түшмэл 11 буюу 5.0 хувь, ахлах түшмэл 4 буюу 1.8 хувь, дэс түшмэл 200 буюу 92.5 хувийг тус тус эзэлж байна.

Хоёр. Үндсэн хэсэг

74.1.1. Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалт болон төрийн албан хаагч, уг албанд нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн маргааныг хянан шийдвэрлэсэн дүн:

Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсээс 2020 онд хяналт-шинжилгээ, үнэлгээг нийт 38 удаа хийж, тухай бүр холбогдох байгууллага болон удирдлагад илтгэх хуудсаар танилцуулж ажилласнаас бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд 8, байгууллагын үйл ажиллагаанд 2, байгууллагын нээлттэй байдалд 1, байгууллагын дотоод үйл ажиллагаанд 27 удаагийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийжээ.

Тайлант хугацаанд төрийн албан хаагчийг албан тушаалд нэр дэвшүүлэх, томилохтой холбоотой нэр дэвшигчийн эрх зөрчигдсөн маргаан гараагүй болно.

74.1.2. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт, зөрчлийн талаарх дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал:

Төрийн албаны тухай хууль, холбогдох дүрэм, журмын хүрээнд албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг агентлагийн удирдлагын өмнө Захиргаа, удирдлагын газар болон байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөл хариуцах чиг үүргийн дагуу бодлогын зөвлөгөө, дэмжлэгээр ханган ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн Ёс зүйн зөвлөл нь Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Гадаадын иргэн, харьяатын газрын “Ажил, үйлчилгээний стандарт”, “Хөдөлмөрийн дотоод журам”, “Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн ёс зүйн дүрэм”-ийг баримтлан ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг мөрдөн ажилладаг.

Тус байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөл нь албан хаагчдын саналыг бичгээр авсны үндсэн дээр байгууллагын даргын 2019 оны А/129 дүгээр тушаалаар 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, түүний ажиллах журмыг мөн 2019 оны А/279 дүгээр тушаалаар баталснаар үйл ажиллагаандаа мөрдлөг болгон Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус зөвлөл нь Гадаадын иргэн, харьяатын газрын төв болон орон нутаг дахь нэгжийн нийт албан хаагчид холбогдох ёс зүйн зөрчилд холбогдсон эсэх асуудлыг шийдвэрлэж байгаа билээ.

Ёс зүйн зөвлөлийн 2 гишүүн өөр байгууллагад шилжин томилогдсон тул 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 6.2-т “...төрийн албан хаагчдын саналыг үндэслэн томилох эрх бүхий албан тушаалтныг гурван жилийн хугацаагаар томилно” гэснийг үндэслэн “Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нөхөн сонгох”-оор заасны дагуу байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн 2 гишүүнийг нөхөн сонгох зорилгоор зохион байгуулсан санал асуулгад нийт 222 албан хаагч хамрагдсан бөгөөд хамт олны олонхын санал авсан Захиргаа, удирдлагын газрын тайлан, төлөвлөгөө хариуцсан ахлах мэргэжилтэн О.Одгэрэл, Санхүү, хангалт, үйлчилгээний газрын худалдан авалт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Анхбаяр нарыг агентлагийн даргын 2020 оны 12 дугаар сарын 03-ны Б/356 дугаар тушаалаар батлав.

Мөн байгууллагын даргын 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн “Байгууллагад гаргасан өргөдөл, гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэх ажлыг сайжруулах тухай” 06 дугаар албан даалгавар гарсан бөгөөд түүнд албан хаагчийн ёс зүй, үйлчилгээний стандарт зөрчсөн, хүнд суртал болон бусад

асуудлаар ирүүлсэн гомдлын мөрөөр тодорхой арга хэмжээ авч, үр дүнг албан хаагчдад мэдээлж байх заалтыг орууллаа.

Тайлант хугацаанд Ёс зүйн зөвлөл нь байгууллагын албан хаагчид холбогдох гомдлоор 4, мэдээллээр 2, дотоод хяналт шалгалтаар 1 буюу нийт төрийн захиргааны 9, төрийн үйлчилгээний 1, нийт 10 албан хаагчид холбогдуулан гаргасан ёс зүйн зөрчлийн шинжтэй үйлдлийг 5 удаагийн хуралдаанаар хянан хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд: Төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлээгүй, төрийн албан хаагчийн нийтлэг үүргээ зөрчсөн, байгууллагын нэр хүндийг иргэдийн дунд унагасан гэж дүгнэж сахилгын шийтгэл ногдуулах саналыг 4 албан хаагчид холбогдуулан байгууллагын даргад уламжилсан бол гаргасан ёс зүйн зөрчлийн шинжийг харгалзан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-д заасан ёс зүйн уучлал гуйхыг үүрэг болгох хариуцлагыг 1, ёс зүйн сануулах хариуцлагыг 1, ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй 2, Хүний эрхийн Үндэсний Комиссын ирүүлсэн шаардлагын хамт байгууллагын даргын дэргэдэх зөвлөлөөр шийдвэрлүүлэхээр уламжилсан 2 албан хаагчид холбогдуулан тогтоол гаргасан.

Ёс зүйн зөвлөлөөс ирүүлсэн санал, дүгнэлтийн дагуу 3 албан хаагчийг төрийн албанаас чөлөөлж, 1 албан хаагчид сануулах сахилгын шийтгэл ногдуулсан. Мөн 1 албан хаагчид “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-д зааснаар нийт албан хаагчдын өмнө мэдээллийн цагаар уучлал гуйх хариуцлага хүлээлгэж, шийдвэрийг хувийн хэрэгт хавсаргалаа.

Тайлант хугацаанд байгууллагын хэмжээнд хууль тогтоомж, дотоод журмын дагуу нийт 31 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсны 29 буюу 93.5 хувийг төрийн захиргааны албан хаагчид эзэлж байна. Сахилгын шийтгэл ногдуулсан төрлөөр авч үзвэл ажлаас халах 6 буюу 19.3, албан тушаалын цалинг бууруулах 11 буюу 35.4, сануулах 14 буюу 45.6 хувийг тус тус эзэлж байна.

Тус байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын дагуу ёс зүйн хариуцлагын талоныг 2017 оноос эхлэн ашиглаж эхэлсэн бөгөөд талоныг ажил үйлчилгээний стандарт, төрийн болон байгууллагын нууцын хадгалалт хамгаалалт, дүрэмт хувцас өмсөх, хэрэглэх журам зөрчсөн болон өгсөн үүрэг даалгавар хангалтгүй биелүүлсэн, бүрэн биелүүлээгүй, албаны сургалт олон нийтийн ажилд оролцоогүй гэсэн үндэслэлээр цоолж сануулга өгч хэвшсэн.

Энэ оны дүнгээр төв болон орон нутгийн 19 албан хаагчийн “Ёс зүйн хариуцлагын талон”-д сануулах тэмдэглэгээ хийгдсэн бөгөөд 3 удаа тэмдэглэгээ хийлгэсэн тохиолдол сахилгын шийтгэл оногдуулах зохицуулалтыг хөдөлмөрийн дотоод журамд тусган мөрдөж байна.

Тус байгууллагад төрийн албан хаагчтай холбоотой сахилгын болон ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны хамтарсан 36/32 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 2.2-т заасны дагуу Захиргаа, удирдлагын газрын дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн журамд заасны дагуу шалган тогтоосны дараа Ёс зүйн зөвлөл эсхүл байгууллагын Даргын дэргэдэх зөвлөлөөр оруулж, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр сахилгын



болон ёс зүйн шийтгэлийг ногдуулж байна. Мөн Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа заавал зохион байгуулж хэвшсэн болно.

74.1.3. Төрийн албаны тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал:

Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай” 275 дугаар тогтоолын хэрэгжилт нь Төрийн албаны тухай хуульд заасан мерит зарчим, төрийн албан тушаалд тавих тусгай шаардлагын дагуу шатлан дэвших боломжийг бүрдүүлэхгүй байна. Агентлагт ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаал хэлтсийн даргаас өөр байхгүйгээс ахлах түшмэлийн албан тушаалыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын бүтцэд хэлтсийн тоог нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал юм. Шийдвэрлүүлэх саналын тухайд:

1. Агентлагт яамдын жишгээр ахлах шинжээч, шинжээч гэсэн ахлах түшмэлийн ангилал, зэрэглэлд хамаарах албан тушаалыг бий болгох;
2. Агентлагийн улсын ахлах байцаагчийн албан тушаалыг ТЗ-9 буюу ахлах түшмэлийн ангилалд, ахлах мэргэжилтний албан тушаалыг ТЗ-8, мэргэжилтний албан тушаалыг ТЗ-7 ангилалд оруулж шинэчлэн батлах;

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын хүрээнд агентлагийн дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Төрийн албаны зөвлөлтэй хамтран ажиллах ажлын уялдаа холбоог зөвхөн тайлан мэдээ өгөх хэмжээнд бус үйл ажиллагааны үр дүнд ахиц гаргаж, Төрийн албаны тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг салбар, нэгжид эрчимжүүлэх шаардлага байна. Шийдвэрлүүлэх саналын тухайд:

1. Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг орон тооны болгох, тухайн байгууллагын бүтэц, орон тоонд оруулах боломжтой;
2. Нарийн бичгийн даргын албан тушаалын ангилал, зэрэглэлийг ахлах шинжээч буюу ТЗ-10 ангилалд оруулж, албан тушаалын ангилал, зэрэглэлд оруулж батлах;

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-д гадаад хэлний шаардлагыг ямар шалгуураар тогтоох, гадаад хэлний түвшин тогтоох шалгалт өгсөн тухай баримт бичгийг юуг үндэслэх чиглэлээр баримтлах тодорхой заавар, чиглэл зохицуулалтгүйгээс гадаад хэлний шаардлагыг хангуулах, тодорхойлох эрх зүйн үндэслэл бүрдээгүй.

Манай байгууллагын хувьд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 57 дугаар тогтоолыг үндэслэн байгууллагын даргын 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар баталсан албан тушаалын тодорхойлолтод ахлах мэргэжилтэн болон мэргэжилтний албан тушаалд тавигдах тусгай шаардлагын ур чадварын бусад хэсэгт “орос, хятад, англи болон гадаадын орны аль нэг хэлийг дундаас дээш түвшинд эзэмшсэн байх” шаардлага байгаа нь салбарын болон ажил, мэргэжлийн онцлогтой холбоотой зайлшгүй гадаад хэлний шаардлагыг



тодорхойлох хэрэгцээ бөгөөд тухайн албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтад орох иргэнийг бүртгэх аргачлал шаардлагатай байна. Шийдвэрлүүлэх саналын тухайд:

1. Гадаад хэлний шаардлага тавигдсан албан тушаалд иргэнийг бүртгэхдээ баримтлах аргачлалыг журамд шинээр тусгах;
2. Төрийн байгууллагад гарсан сул орон тоог нийтэд зарлахын өмнө Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар шилжин болон сэлгэн ажиллах хүсэлтэй төрийн жинхэнэ албан хаагчдад эхний ээлжинд зарлаж, тэдэнд давуу эрх, боломжийг олгож, хуулийн хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлэх;

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын шилжин ажиллах зохицуулалт зөвхөн байгууллага хооронд үйлчилж байгаа нь байгууллагын нэгж /газар, хэлтэс/ хооронд төрийн жинхэнэ албан хаагчийн шилжин ажиллах эрх зүйн үндэслэлгүй болгож байна. Шийдвэрлүүлэх саналын тухайд:

1. Төрийн байгууллагад гарсан сул орон тоог нийтэд зарлахын өмнө Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд байршуулж, шилжин болон сэлгэн ажиллах хүсэлтэй төрийн жинхэнэ албан хаагчдад боломж олгох;
2. Байгууллагын дотор нэгж хооронд шилжин ажиллах зохицуулалтыг журамд тусгах;

Дээрх Засгийн газрын 1 тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2 журам, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан тушаалаар баталсан 1 журмыг хэрэгжүүлэх явцад хүний нөөцийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл, холбогдох журам, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж шийдвэрлүүлэх саналаа тодорхой тусгалаа.

74.1.4. Мэдлэг, үр чадвар, туршлагад суурилсан, улс төрөөс хараат бус, шударга, ил тод, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааны талаар цаашид авах арга хэмжээний санал:

Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах 2017-2020 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсээс гүйцэтгэлийн үнэлгээг хийж байгаа бөгөөд хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дууссантай холбогдуулан шинээр боловсруулах Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах, нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт зохион байгуулалтын нэгжүүдээс санал авах ажлыг зохион байгуулж байна.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоолоор баталсан "Түрээсийн орон сууц" хөтөлбөр, 2019 оны 138 дугаар тогтоолоор баталсан "Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам"-ын дагуу хилийн хяналтын болон хуулиар тусгайлан заасан чиг үүргийг гүйцэтгэдэг тус байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх тухай албан бичгийг Монгол Улсын Шадар

сайдад хүргүүлснээр Засгийн газраас хэрэгжүүлж байгаа түрээслэн өмчлөх орон сууцны хөтөлбөрт 4 албан хаагчийг хамруулав.

Нийслэлийн авто замын түгжрэл, байгууллагын төв байр хотын төвөөс алслагдмал байрладаг зэргээс шалтгаалан ажлын цагийн хуваарьт өөрчлөлт оруулах санал асуулгыг төв байрны 2020 оны 11 дүгээр сард албан хаагчдаас авч, 54 албан хаагч оролцсноос 50 албан хаагч 100 хувь ажил эхлэх цагийг 08:00 цаг, дуусах цагийг 16:30 цаг болгох саналыг дэмжсэнээр ажлын цагийн хуваарийг агентлагийн даргын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/263 дугаар тушаалаар өөрчилж, ажлын цагийн шинэ хуваарийг 12 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэллээ.

Тайлант хугацаанд албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан нөхөх төлбөр /албан томилолт, тээвэр шатахуун, замын зардал/-ийг давхардсан тоогоор 184 албан хаагчид 55.6 сая төгрөг, мөн хуулийн 60 дугаар зүйлд заасан тусламжийг 2 иргэнд 131.8 сая төгрөг, 61 дүгээр зүйлд заасан нийтлэг баталгааны хүрээнд 9 албан хаагчид 14.2 сая төгрөг тус тус олгосон.

Зохион байгуулалтын хүрээнд:

Салбар зөвлөлийн хуралдааныг 2020 онд 6 удаа зохион байгуулж, дараах 11 асуудлыг хэлэлцэж, холбогдох тогтоол, чиглэлийг баталлаа. Үүнд:

- 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 01 дүгээр хуралдаанаар: салбар зөвлөлийн хуралдааны дэг, салбар зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд уламжлах асуудлыг хэлэлцэн батлах;
- 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар хуралдаанаар: салбар зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг хэлэлцэн батлах, төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв шинээр болон ахиулан олгох санал Хууль зүй, дотоод хэргийн яаманд уламжлах;
- 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 03 дугаар хуралдаанаар: гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалт зохион байгуулах шалгалтын комисс байгуулж, чиглэл өгөх;
- 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дүгээр хуралдаанаар: гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалт зохион байгуулсан шалгалтын комиссын тайланг хэлэлцэх;
- 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар: салбар зөвлөлийн эхний хагас жилийн тайлан, төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэх;
- 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар хуралдаанаар: салбар зөвлөлийн үйл ажиллагааны танилцуулга, төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагаа зохион байгуулах тухай, байгууллагын дэргэдэх Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны мэдээллийг хэлэлцэх;



Салбар зөвлөл нь жилийн дүнгээр 11 тогтоол баталж, хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:

- Салбар зөвлөлийн хуралдааны дэгийг батлах тухай 01 дүгээр тогтоол;
- 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 19 арга хэмжээ тусган хэрэгжүүлэхээр баталсан 02 дугаар тогтоол;
- Салбар зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлах тухай 03 дугаар тогтоол;
- Гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх шалгалтын комиссыг байгуулах тухай 04, 11 дүгээр тогтоол;
- Нэр дэвшүүлэх тухай 05, 06, 07 дугаар тогтоол;
- Зэрэг дэв олгох санал Хууль зүй, дотоод хэргийн яаманд уламжлах тухай 08 дугаар тогтоол;
- Салбар зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгох тухай 09 дүгээр тогтоол;
- Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлэх тухай 10 дугаар тогтоол;

Салбар зөвлөлд 2020 оны дүнгээр Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн албан бичиг, зөвлөмжийн тоо 8, явуулсан албан бичгийн 7, үүнээс хариутай 4 албан бичгийг заасан хугацаанд бүрэн хүргүүлэв.

Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх хүрээнд:

Төрийн албаны хүний нөөцийн мэдээллийн систем, Сангийн яамны цалингийн нэгдсэн системд холбогдсоноор 2020 онд байгууллагын төв, орон нутаг дахь газрын давхардсан тоогоор 1183 албан хаагчийн цалин, сар бүрийн тогтмол нэмэгдэл, нийтийн тээвэр, хоолны хөнгөлөлт, 573 албан хаагчийн зэрэг дэв, 503 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, 76 албан хаагчийн хавсран ажилласан болон бусад төрлийн нэмэгдэл мэдээллийг шинэчлэн оруулж, тухай бүр баяжилтийг хийж хэвшсэн.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын 3.1.1-т “хувийн хэргийг анх бүрдүүлэхдээ үндсэн баримт бичгийг дарааллын дагуу цахим болон бичгийн хэлбэрээр бүрдүүлж, хавтас үүсгэн хадгалах” гэж заасны дагуу 2020 онд нийт 266 албан хаагчийн 13706 хуудас хувийн хэргийг скайнердаж, дотоод мэдээллийн системд цахимаар оруулан албан хэрэгцээнд ашиглаж байна.

“Хувийн хэрэг хөтлөх журам”-ын 1.6-д зааснаар төрийн байгууллага хооронд шилжин ажиллах болсон 7 албан хаагчийн хувийн хэргийн эх хувийг жагсаалтын хамт 623 хуудас материалыг бусад байгууллагад шилжүүлсэн. Төрийн албан хаагчтай холбоотой үндсэн баримт бичиг болон бусад шаардлагатай тушаал шийдвэрийг тухай бүр албан хаагчийн хувийн хэрэгт баяжилтаар хийж, энэ онд шинээр 29 хувийн хэрэг бүрдүүлэв.



Төрийн албаны нөөц бүрдүүлэх хүрээнд:

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын 3.5-д заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаал эрхэлж байгаа 181 албан хаагчийн нөөцийн бүртгэл, төрийн жинхэнэ албанаас чөлөөлөгдсөн 10 албан хаагчийн болон иргэний нөөцийн бүртгэлийг батлагдсан загварын дагуу хийж, эхний хагас жилд Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлөөс цахимаар ирүүлсэн чиглэлийн дагуу төрийн захиргааны тэргүүн, эрхэлсэн, ахлах, дэс түшмэлийн ангилалд хамаарах нийт 116 албан хаагчийн дэлгэрэнгүй судалгааг нэгтгэн 05 дугаар сард sodnomish@csc.gov.mn хаягаар хүргүүлж ажиллалаа.

Байгууллагын удирдах албан тушаалд ажиллаж байгаа 16 албан хаагч, удирдах албан тушаалд дэвшин ажиллах боломжтой 15 албан хаагчийн судалгаа, төрийн албан хаагчийн анкет, албан тушаалын тодорхойлолтуудыг бэлтгэж, 03 дугаар сард Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Маргаан хянан шалгах хүрээнд:

Байгууллагын төв болон орон нутаг дахь бүтцийн нэгжүүдийн хэмжээнд УИХ-ын болон орон нутгийн ээлжит сонгуулийн үр дүнгээр төрийн албан хаагчдыг хууль бусаар ажлаас халах, чөлөөлөх зөрчлийг гаргаагүй болно.

Хяналт шалгалтын газрын хяналтын улсын байцаагч Н.Дуламсүрэнгийн гаргасан гомдлыг Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газраас шалгаад 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 367 дугаар тогтоолоор агентлагийн даргын “Н.Дуламсүрэнд сахилгын шийтгэл ногдуулах тухай” Б/249 дүгээр тушаалыг холбогдох хууль, журмыг зөрчөөгүй болохыг тогтоосон.

Төрийн албаны шалгалт зохион байгуулах хүрээнд:

2020 оны дүнгээр гүйцэтгэх албан тушаалын 9 сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 03 дугаар албан бичгээр хүргүүлснээр Төрийн албаны зөвлөлөөс зарыг 04 дүгээр сард “www.csc.gov.mn” цахим хаягаар болон байгууллагын “immigration.gov.mn” цахим хуудсаар нийтэд хүргэсэн.

Салбар зөвлөлийн захиалгаар удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөл 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, шалгалтад тэнцсэн Агаарын замын боомт хариуцсан газрын даргаар З.Даваасүрэнг нэр дэвшүүлсэн тухай 192 дугаар тогтоол, Баруун бүс дэх газрын даргаар А.Хуанбайг нэр дэвшүүлсэн 193 дугаар тогтоол ирүүлснээр Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 140, 141 дүгээр тушаалаар албан тушаалд томилон, мэдээг Төрийн албаны зөвлөлд 05 дугаар сарын 22-ны өдрийн 01/897 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

Тайлант хугацаанд удирдах албан тушаалын 2, гүйцэтгэх албан тушаалын 3 сул орон тоог нөхөж, нөхөгдөөгүй гүйцэтгэх 6 албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах шалгалтын комиссыг салбар зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор батлаад байна.

Сургалт судалгаа, сурталчилгаа хийх хүрээнд:

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны 2020 оны үйл ажиллагааны тэргүүлэх зорилтууд”-ыг нийт албан хаагчдад танилцуулан байгууллагын immigration.gov.mn цахим хаягт байршуулж, олон нийтэд хүргэлээ.

Төрийн албаны зөвлөлийн “Зохион байгуулалтын зарим арга хэмжээний тухай” 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 01, “Төрийн албанд ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах тухай” 06 дугаар сарын 18-ны өдрийн 02, “Төрийн албаны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тухай” 10 дугаар сарын 28-ны өдрийн 03, “Сургалтын бодлогыг хэрэгжүүлэх тухай” 11 дүгээр сарын 05-ны өдрийн 04 дүгээр зөвлөмж, COVID-19 “Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангах нь” цахим гарын авлага болон холбогдох журам, дүрмийг төв болон орон нутаг дахь газрын нийт албан хаагчдад дотоод сүлжээгээр хүргүүлэн байгууллагын цахим хуудсанд байршуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн нэгдсэн сургалт 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрөөс 11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд байгууллагаас хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн оролцсон. Тус сургалтаас өгсөн чиглэлийн дагуу сонгон шалгаруулалт, маргаан хянан шийдвэрлэлт, хүний нөөцийн аудит, төрийн албан хаагчийн ёс зүй, нэгдсэн тоо бүртгэл, төрийн албан хаагчийн сургалтууд, жендер, цалингийн нэгдсэн систем болон төрийн бодлого, чиг хандлагын талаар 01 дүгээр сарын 14-ний өдөр төвийн 54, орон нутаг дахь газрын 71 нийт 125 албан хаагчид мэдээлэл хийсэн.

Байгууллагын 2020 оны сургалтын төлөвлөгөөний дагуу “Удирдах албан тушаалтан, албан хаагчдын цугларалт, сургалт, “Хяналтын улсын байцаагчийн эрх олгох сургалт”, “Худалдан авах ажиллагааны эрх олгох /АЗ/ сургалт”, “Орон нутаг дахь газрын албан хаагчдыг дадлагажуулах сургалт”-ыг тус тус зохион байгуулсан. Мөн албан хаагчдын мэдээллийн цагаар “Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлт”, “Гүйцэтгэлийн төлөвлөгөө үнэлэх аргачлал”, “ХАСХОМ-ийг хэрхэн мэдүүлэх”, “Төрийн албаны шинэтгэл” сэдвээр тус тус сургалт, мэдээллийг зохион байгуулж давхардсан тоогоор байгууллагын төвийн 104, онлайн хэлбэрээр орон нутаг дахь газар, хэлтсийн 78 албан хаагч тус тус хамрагдлаа.

Удирдлагын академиас зохион байгуулсан богино хугацааны мэргэшүүлэх сургалтад 3, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад 1, давтан сургалтад 1, төрийн захиргааны менежментийн дипломын сургалтад 1, нийт 5 албан хаагч хамрагдаж төгссөнөөс гадна эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, дунд хугацааны мэргэшүүлэх давтан сургалтад 2 албан хаагч хамрагдлаа.

Түүнчлэн Монголын Хэвлэлийн Хүрээлэнгээс зохион байгуулсан олон нийттэй харилцах мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх дээд курсийн дипломын сургалтад 1, Бүгд Найрамдах Таджикстан Улсын Душанбе хот дахь Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Хилийн менежментийн коллежид зохион байгуулагдах “Хилийн менежмент аюулгүй байдлыг хангах чиг

үүрэгтэй байгууллагуудын ахлах, дунд түвшний албан хаагчдын 26 дахь удаагийн сургалтад 1 албан хаагчийг тус тус хамрууллаа.

Ёс зүйн зөвлөлөөс “Удирдах албан тушаалтан, албан хаагчдын цугларалт”, “Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн эрх олгох сургалт”-ын үеэр “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ын талаар сургалт зохион байгуулж, мөн байгууллагын мэдээллийн цагаар нийт албан хаагчдад ёс зүйн зөрчилд холбогдсон албан хаагчдын болон шийдвэрлэлтийн талаар мэдээлэл хүргүүлж, цаашид энэ талаар анхаарч, хувийн болоод албаны ёс зүйн үүрэг хариуцлагатай байхыг уриалж ажилласан.

Салбар зөвлөлийн ажиллах төлөвлөгөөнд тусгасны дагуу төрийн албанд ажиллах хүсэл сонирхолтой их дээд сургууль төгссөн залуучуудад чиг баримжаа олгох сургалт, дадлагыг анх удаа ажлын 5 өдөр зохион байгууллаа. Тус сургалтад 7 иргэн хамрагдсан бөгөөд байгууллагын үйл ажиллагаа, үндсэн чиг үүрэгтэй танилцуулж, Төрийн албаны тухай хууль, тогтоомж, ерөнхий болон тусгай шалгалт өгөх талаар заавар, зөвлөмж өглөө.

Хүний нөөцийн бодлогын хүрээнд:

Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох 24 албан хаагчийн судалгааг нэгтгэж, салбар зөвлөлийн 03 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн 8 албан хаагчид зэрэг дэв олгох саналыг гаргасан. Тус хуралдаанаар шийдвэрийн дагуу агентлагийн дарга зэрэг дэв олгож болох эсэх талаар чиглэл авахаар 03 дугаар сарын 30-ны өдрийн 01/613 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, 01/614 дүгээр албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг нарт тус тус хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 04 дүгээр сарын 13-ны өдрийн 1/1510 дугаар албан бичгээр 01/613 дугаар албан бичгийн хариу ирсэн бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/82 дугаар тушаалаар төрийн захиргааны 2 албан хаагчид зэрэг дэвийг шинээр, 6 албан хаагчид зэрэг дэвийг ахиулан олголоо.

Мөн эрхэлсэн түшмэлийн зэрэг дэвийн олгуулахаар 5 газрын даргын холбогдох материалыг бүрдүүлж, 03 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн даргад хүргүүлсэн.

Тус байгууллагын төв, орон нутгийн бүтцийн нэгжүүдэд ажиллаж байгаа 216 төрийн захиргааны албан хаагчийн 135 буюу 62.5 хувь нь зэрэг дэвтэй, мэргэшсэн албан хаагчид ажиллаж, сар бүр 18-36 хувийн нэмэгдэл олгож байна.

Зэрэг дэвтэй төрийн захиргааны албан хаагчдын 7 буюу 3.2 хувийг эрхэлсэн түшмэл, 68 буюу 31.4 хувийг ахлах түшмэл, 60 буюу 27.7 хувийг дэс түшмэл тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/14 дүгээр тушаалаар 6 албан хаагч Хүндэт жуух бичгээр, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 123 дугаар зарлигаар “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар 4 албан хаагч, 2020 онд нийтдээ төрийн дээд одон медаль, салбарын болон байгууллагын

шагналаар 73 албан хаагч шагнагдаж, холбогдох зардалд 1.231.053 төгрөг зарцууллаа.

Гурав. Бусад хэсэг

Төрийн албаны хууль тогтоомж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 22-ны өдөр байгууллагын удирдлага, албан хаагчидтай уулзах үед өгсөн үүрэг, чиглэлийн дагуу албан хаагчдын ажлын байранд зураг авалт хийн ажлын ачаалал, чиг үүргийн давхардлыг тогтоох, шаардлагатай болон шаардлагагүй орон тооны тооцоо, судалгаа гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгууллагын даргын 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/183 дугаар тушаалаар байгуулав.

Албан хаагчдын ажлын байрны зураг авалтыг 2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн батлагдсан удирдамжийн дагуу албан хаагчдын ажлын нэгж өдрийн цагийн зураглал, тэмдэглэл хөтлөх, асуулга авах аргаар хийж, 2019 оны эхний хагас жил, 2020 оны эхний хагас жилийн тайлан, статистик тоон үзүүлэлт, албан тушаалын тодорхойлолт, батлагдсан орон тооны бүтэц, нэгжийн онцлог зэрэгт тулгуурлан харьцуулсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргалаа.

Захиргаа, удирдлагын газар 10, Виз, зөвшөөрөл, харьяатын газар 18, Хяналт шалгалтын газар 12, Санхүү, хангалт, үйлчилгээний газар 10, Эрх зүй, гадаад харилцааны хэлтэс 4, Мэдээллийн технологийн хэлтэс 4, Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсийн 3, орон нутаг дахь 7 нэгжийн 118, нийт байгууллагын хэмжээнд 91 албан тушаалд 181 албан хаагч буюу 70.9 хувийг ажлын байрны зураг авалтад хамруулав.

Тус байгууллагын бүтцэд батлагдсан 306 орон тооны 216 буюу 70.5 хувь нь төрийн захиргааны, 90 буюу 29.4 хувийг төрийн үйлчилгээний ажлын байр эзэлж байна. Төрийн захиргааны нийт 216 албан тушаалыг бүтцийн нэгжээр болон түшмэлийн ангилалаар дараах хүснэгтэд нэгтгэн харуулав.

| № | Бүтцийн нэгжийн нэр | Түшмэлийн ангилал | | | Тоо | Эзлэх хувь |
|------------|---|-------------------|-----------------|--------------|-----------|------------|
| | | Тэргүүн түшмэл | Эрхэлсэн түшмэл | Ахлах түшмэл | | |
| 1 | Агентлагийн удирдлага | 1 | 1 | | 2 | 2.3 |
| 2 | Захиргаа, удирдлагын газар | | 1 | | 15 | 18.8 |
| 3 | Виз, зөвшөөрөл, харьяатын газар | | 1 | | 31 | 37.6 |
| 4 | Хяналт, шалгалтын газар | | 1 | | 16 | 20.0 |
| 5 | Санхүү, хангалт, үйлчилгээний газар | | 1 | | 1 | 1.1 |
| 6 | Эрх зүй, гадаад харилцааны хэлтэс | | | 1 | 6 | 7 |
| 7 | Мэдээллийн технологийн хэлтэс | | | 1 | 1 | 1.1 |
| 8 | Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэс | | | 1 | 8 | 10.5 |
| ДҮН | | 1 | 5 | 3 | 76 | 85 |
| 9 | Агаарын замын боомт хариуцсан газар | | 1 | | 23 | 24 |

| | | | | | | | |
|------------|------------------------------|------------|------------|------------|-------------|------------|------|
| 10 | Дорноговь аймаг дахь газар | | 1 | | 18 | 19 | 14.5 |
| 11 | Зүүн бүс дэх газар | | 1 | | 19 | 20 | 15.2 |
| 12 | Өмнөд бүс дэх газар | | 1 | | 13 | 14 | 10.6 |
| 13 | Хойд бүс дэх газар | | 1 | | 25 | 26 | 19.8 |
| 14 | Баруун бүс дэх газар | | 1 | | 19 | 20 | 15.2 |
| 15 | Баян-Өлгий аймаг дахь хэлтэс | | | 1 | 7 | 8 | 6.1 |
| ДҮН | | | 6 | 1 | 124 | 131 | |
| НИЙТ ДҮН | | 1 | 11 | 4 | 200 | 216 | |
| ЭЗЛЭХ ХУВЬ | | 0.4 | 5.0 | 1.8 | 92.5 | | |

Тус байгууллагад ахлах түшмэлийн ангилалд хамаарах хэлтсийн даргын ажлын байр 4 буюу 1.8 хувийг эзэлж байгаа нь төрийн захиргааны нийт 216 албан тушаалын 200 буюу 92.5 хувийг эзэлж байгаа дэс түшмэлийн ангилалд хамаарах мэргэжилтнүүдэд Төрийн албаны тухай хуульд заасан мерит зарчим, төрийн албан тушаалд тавих тусгай шаардлагын дагуу шатлан дэвших боломж бүрдүүлэхгүй байгааг харгалзан ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалыг нэмэгдүүлэх саналтай байна.

Тус агентлагийн төв болон орон нутгийн нэгжид ажлын байрны зураг авалтын үр дүнг үндэслэн тухайн нэгжид байгаа сул орон тоог бүрэн нөхөж ажиллуулах, бүтцийн нэгжээс гаргасан саналын дагуу зарим ажлын байрны орон тоог цөөрүүлэх, хариуцах ажлын чиг үүргийг нэгтгэх замаар ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ачаалал багатай, бусад албан тушаалд ажлыг нэгтгэн гүйцэтгэх боломжтой газруудын зарим ажлын байрыг шаардлагатай бусад нэгжүүдэд болон Агаарын замын боомт хариуцсан газарт шинээр байгуулах Буюнт-Ухаа дахь нэгжид шилжүүлэх дүгнэлт, тооцооллыг гаргаж, агентлагийн удирдлагад танилцуулсан.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөртэй уялдуулан 16 зорилтын хүрээнд 62 арга хэмжээ бүхий “Гадаадын иргэн, харьяатын газраас авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2020 онд авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”, 10 зорилтын хүрээнд 11 арга хэмжээ бүхий “Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г тус тус батлан хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллалаа.

Тайлант хугацаанд шинээр томилогдохоор нэр дэвшсэн 29, шилжин томилогдохоор нэр дэвшсэн 28, дэвшин томилогдохоор нэр дэвшсэн 15, сэлгэн ажиллахаар нэр дэвшсэн хоёр, нийт 74 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч, Авлигатай тэмцэх газарт хянуулан зөрчилгүй дүгнэлтийг үндэслэн томилгоог хууль тогтоомжийн хүрээнд хийлээ.

Дөрөв. Дүгнэлт

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 309 дүгээр тогтоолоор манай байгууллагын салбар зөвлөлийг татан буулгасан хэдий ч 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөл дахин байгуулагдсан билээ.

Үүний үр дүнд Монгол Улсын хилийн хяналт, Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг болон хуулиар тусгайлан заасан чиг үүргийг гүйцэтгэдэг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх



салбар зөвлөлийн хувьд гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалт зохион байгуулах, албан хаагчийн зэрэг дэвийг ахиулах, шинээр олгуулах санал гаргах, Төрийн албаны тухай хууль тогтоомжийг салбарын эрх зүйн зохицуулалтад нийцүүлэн салбарын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг бие даан шийдвэрлэх боломж нөхцөл бүрдээд байна.

Тав. Санал

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж эхэлснээс хойших хугацаанд хуулийг дагалдаж батлагдсан тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх явцад тухайн Засгийн газрын агентлагийн нийт албан хаагчдын 90 гаруй хувийг эзэлдэг гүйцэтгэх албан тушаалд ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой эрх зүйн байдал өмнөх Төрийн албаны хууль хэрэгжиж байсан үеэс зарим талаар дордоод байгаа билээ.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд мэргэшсэн чадварлаг хүний нөөцийн үндэсний тогтолцоог бүрдүүлэх, төрийн албаны шинэтгэлийг дунд шатанд эрчимжүүлэх, агентлагт ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдын нийгмийн баталгааг дээшлүүлэх, иргэдийн итгэлийг хүлээсэн ёс зүйт төрийн албыг төлөвшүүлэх, агентлагийн дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажлын журамд заасан чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд ахиц гаргах зорилтуудын хүрээнд эн тэргүүнд холбогдох зарим шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах дараах саналыг багцлан танилцуулж байна.

Нэг. Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай” 275 дугаар тогтоол нь агентлагийн түвшинд Төрийн албаны тухай хуульд заасан мерит зарчим, төрийн албан тушаалд тавих тусгай шаардлагын дагуу шатлан дэвших боломжийг бүрдүүлэхгүй байна. Агентлагт ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаал хэлтсийн даргаас өөр байхгүйгээс ахлах түшмэлийн албан тушаалыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын бүтцэд хэлтсийн тоог нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал байгаа юм.

Иймд агентлагт яамдын жишгээр ахлах шинжээч, шинжээч гэсэн ахлах түшмэлийн ангилал, зэрэглэлд хамаарах албан тушаалыг бий болгох;

Агентлагийн улсын ахлах байцаагчийн албан тушаалыг ТЗ-9 буюу ахлах түшмэлийн ангилалд, ахлах мэргэжилтний албан тушаалыг ТЗ-8, мэргэжилтний албан тушаалыг ТЗ-7 ангилалд оруулж шинэчлэн батлах;

Дээрх зохицуулалтыг төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах Засгийн газрын тогтоолд тусгуулснаар одоо мөрдөгдөж байгаа ахлах түшмэлийн ангилалд зөвхөн ТЗ-9, ТЗ-10 гэсэн 2, дэс түшмэлийн ангилалд ТЗ-4-өөс ТЗ-8 хүртэл 5 ангиллын албан тушаал хамрагдаж байгаа тэгш бус байдлыг арилгаж, мөн өмнөх хуулийн хүрээнд улсын ахлах байцаагч нар ТЗ-8 ахлах түшмэлийн ангилалд хамрагдаж байгаад одоогийн шинэ зохицуулалтаар дэс түшмэл болж буурсан гажуудлыг арилгаснаар Төрийн албаны тухай хуулийн шатлан дэвшүүлэх тогтолцоо, чадахуйн зарчим хэрэгжих үндсэн нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Хоёр. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын хүрээнд агентлагийн дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Төрийн албаны зөвлөлтэй хамтран ажиллах ажлын уялдаа холбоог зөвхөн тайлан мэдээ өгөх хэмжээнд бус үйл ажиллагааны үр дүнд ахиц гаргаж, Төрийн албаны тухай хууль, холбогдох журмын хэрэгжилтийг салбар, нэгжид эрчимжүүлэх шаардлага байна.

Иймд агентлагийн дэргэдэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг орон тооны болгосноор тухайн байгууллага өөрсдөө бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулан ажиллуулах боломжтой;

Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалын ангилал, зэрэглэлийг ахлах шинжээч буюу ТЗ-10 ангилалд оруулж, Засгийн газраас тогтоосон төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлд нэмэлтээр тусгаж батлах;

Дээрх саналыг холбогдох эрх зүйн актад тусгаж баталснаар агентлагийн дэргэдэх салбар зөвлөлийн холбогдох журамд заасан чиг үүргээс хэрэгжилт нь учир дутагдалтай байгаа хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хүний нөөцийн аудит хийх, төрийн алба, албан хаагчдын талаар судалгаа шинжилгээ хийх, судалгаанд суурилсан төрийн албаны шинэтгэл, хүний нөөцийн бодлого, үйл ажиллагааг нэвтрүүлэх ажлуудын хэрэгжилт, үр дүнд томоохон ахиц, дэвшил гарч, төрийн албаны шинэтгэлийн үзэл баримтлал хэрэгжих боломж бүрдэх болно.

Зургаа. Хавсралт

Хавсралт 14 төрлийн судалгааг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудасны “үйл явдал” хэсгээс татан авч, тайланд хавсаргасан бөгөөд судалгаа, мэдээллийг гаргасан талаарх тайлбарыг дараах хүснэгтэд харуулав.

| Хавсралт | Судалгаа, мэдээллийн нэр | Судалгаа, мэдээллийг гаргасан байдал |
|-------------------|--|---|
| 1 дүгээр хавсралт | А. Төрийн албаны зөвлөлийн тогтоол, шийдвэрийн биелэлт, хэрэгжилт | Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор баталсан 10 журам, 4 зөвлөмжийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнав. |
| | Б. УИХ-ын төрийн байгуулалтын, ёс зүй, сахилга хариуцлагын болон инноваци, цахим бодлогын байнгын хорооны дарга нараас өгсөн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл | Байнгын хороодын өгсөн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 12 арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хавсаргав. Тайланг 2020.12.23-ны өдрийн 01/1912 дугаар албан бичгээр ТАЗ-д мөн тайлагнасан. |
| 2 дугаар хавсралт | Салбар зөвлөлөөс 2020 онд зохион байгуулсан төрийн захиргааны удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтын дүн | Энэ онд төсвийн шууд захирагч, орон нутаг дахь 2 газрын даргын сонгон шалгаруулалтыг ТАЗ-өөс зохион байгуулсан бөгөөд салбар зөвлөлөөс зохион байгуулсан |

| | | |
|--------------------|--|---|
| | | удирдах албан тушаалын сонгон шалгаруулалт хийгдээгүй. |
| 3 дугаар хавсралт | Салбар зөвлөлөөс 2020 онд зохион байгуулсан төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын дүн | Энэ онд салбар зөвлөлөөс зохион байгуулсан гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын дүнг маягтаар нэгтгэсэн гаргасан. |
| 4 дүгээр хавсралт | Салбар зөвлөлөөс 2020 онд зохион байгуулсан төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтын дүн | Тус агентлагт төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын ангилалд хамаарах албан тушаал байхгүй тул судалгааг гаргаагүй. |
| 5 дугаар хавсралт | Төрийн албаны тухай хууль тогтоомжийн нөлөөллийн талаар гаргасан санал | Засгийн газрын 1 тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2 журам, ЗГХЭГ-ын дарга, ТАЗ-ийн даргын хамтарсан тушаалаар баталсан 1 журамд хүний нөөцийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөл, холбогдох журам, тогтоолд тусгах саналаа тодорхой тусгалаа. |
| 6 дугаар хавсралт | Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс төрийн жинхэнэ албан хаагчид зэрэг дэв шинээр болон ахиулан олгосон судалгаа | 2020 онд нийт 10 төрийн жинхэнэ албан хаагч хамрагдсанаас зэрэг дэв шинээр авсан 4, ахиулан олгосон 6 байна. Салбар зөвлөлөөс салбарын яаманд уламжлан шийдвэрлүүлсэн. |
| 7 дугаар хавсралт | Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардлын нэгдсэн судалгаа | Судалгааг агентлагийн хэмжээнд 2020 оны дүнгээр нэгтгэн тайлагнав. |
| 8 дугаар хавсралт | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээ | Мэдээг маягтын дагуу 2020 оны дүнгээр нэгтгэсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн тайланг 2020.12.25-ны өдрийн 01/1922 дугаар албан бичгээр ТАЗ-д мөн тайлагнасан. |
| 9 дүгээр хавсралт | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ | Салбар зөвлөлд 2020 онд ирүүлсэн өргөдөл байхгүй. |
| 10 дугаар хавсралт | Зөрчилтэй томилогдсон төрийн захиргааны албан хаагчдын судалгаа | Зөрчилтэй томилогдсон төрийн захиргааны албан хаагч байхгүй тул судалгааг гаргаагүй. |
| 11 дүгээр хавсралт | Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалын зэрэглэлд хамаарах албан тушаал эрхэлж байсан албан хаагчийн удирдах албан тушаалтны нөөцийн бүртгэл | 2020 оны дүнгээр Виз, зөвшөөрөл, харьяатын газрын дарга, эрхэлсэн түшмэл Ч.Нармандах ТАТХ-ийн 46.1.2-т зааснаар түр чөлөөлөгдсөн тул бүртгэлд оруулсан. |
| 12 дугаар хавсралт | Төрийн байгууллагын албан хаагчдын 2020 онд сургалтад | Судалгааг 2020 оны дүнгээр нэгтгэхэд нийт 11 албан хаагч |

| | | |
|--------------------------|---|--|
| | хамрагдсан тухай судалгааны нэгтгэл | хамрагдсаны 63.6 хувь нь эрэгтэй албан хаагчид эзэлж байна. |
| 13 дугаар хавсралт | Төрийн албаны чадавхыг бэхжүүлэх талаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээлэл | Төрийн албаны чадавхыг бэхжүүлэх талаар төсөл, хөтөлбөр хэрэгждэггүй тул мэдээллийг гаргаагүй. |
| 14 дүгээр хавсралт | Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн хөрөнгөөр гадаад орнуудад сурсан болон сурч байгаа төрийн албан хаагчид, тэдгээрийн ажил эрхлэлтийн байдлын талаарх судалгаа | Сүүлийн 4 жил буюу 2016-2020 оны байдлаар Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн хөрөнгөөр сурсан болон сурч байгаа албан хаагч байхгүй боловч БНХАУ-ын Засгийн газрын тэтгэлэгээр сурч байгаа 1, төслийн зардлаар сурсан 1 албан хаагчийн судалгааг гаргасан. |


ТАНИЛЦСАН:

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА


Н.УУГАНБАЯР


ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА, САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮН


Д.ДАВААНЯМ

БОЛОВСРУУЛСАН:

ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН, САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА


В.ШООВДОР

Тайлангийн 1 дүгээр хавсралт

А.ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ХЭРЭГЖИЛТ

2021.01.06.

| № | Шийдвэрийн тэргүү | Огноо, дугаар | Биелэлт (үр дүн) | Хувь |
|----|--|-------------------|--|------|
